ENLIGHT CONTROL SYSTEMS

AVEVA Historian

ТАНИЛЦУУЛГА · Process Data Historian

Эх сурвалж: AVEVA-ийн албан ёсны материал (aveva.com/en/products/historian). Enlight (AVEVA-ийн Монгол дахь албан ёсны дистрибьютор) монгол хэлнээ бэлтгэв. Техникийн зарим нэр томъёог англиар нь үлдээв.

AVEVA Historian гэж юу вэ?

AVEVA Historian нь үйл ажиллагааны удирдлагатай нягт нэгдсэн process historian — үйлдвэрийн процессын (time-series), дохиолол (alarm), үйл явдлын (event) түүхэн өгөгдлийг өндөр нягтралтайгаар цуглуулж, хадгалж, шинжлэх өгөгдлийн сан юм. Дэвшилтэт хадгалалт, шахалтын (compression) техникийг салбарын стандарт query интерфейстэй хослуулснаар багийнхан үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн ойлгож, асуудлыг хурдан оношлож, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргана. Энгийн өгөгдлийн сангаас ялгаатай нь дохиолол, үйл явдлын өгөгдлийг ч зориулалтын дагуу хадгална.

Яагаад Historian вэ?

- Давхардсан өгөгдлийн хувилбар, алдаа, ашиглалтын зардлыг бууруулна
- Асуудлыг хурдан оношилж, процесс сайжруулах боломжийг илрүүлнэ
- Түүхэн өгөгдөлд илүү олон ажилтан хандаж, хамтын ажиллагаа сайжирна
- Уян хатан, өргөтгөх байршуулалтаар IT зардлыг багасгаж, ROI-г хурдасгана
- High-availability (HA), disaster recovery (DR)-аар бизнесийн тасралтгүй байдлыг хангана
- Хадгалалтын зардлыг 80%-иас дээш бууруулдаг (үйлдвэрлэгчийн мэдэгдэл)

Гол боломжууд

History block технологи

Үйлдвэрийн өгөгдлийг энгийн сангаас хэд дахин хурдан цуглуулж (үйлдвэрлэгчийн мэдэгдлээр «хэдэн зуун дахин»), уламжлалт хадгалалтын багахан хэсэгт багтаан хадгална.

Өндөр үр ашигтай хадгалалт

Хэт үр ашигтай хадгалалтын алгоритмаар өгөгдөл хадгалалтын зардлыг 80%-иас дээш бууруулна.

Өгөгдлийн бүрэн бүтэн байдал (data integrity)

Нам зурвасын (low-bandwidth) холболт, хоцорч ирсэн өгөгдөл, цаг нь зөрүүтэй системүүдээс ирэх өгөгдлийг зөв боловсруулж, бүрэн бүтэн байдлыг хадгална.

Богино ба урт хугацааны хадгалалт, дэвшилтэт retrieval

Шуурхай оношилгооны богино хугацааны өгөгдлөөс хууль журмын урт хугацааны архив хүртэл. Өндөр хурдтай цуглуулалт, суурин дэвшилтэт retrieval горимууд query-г хялбар, үр

ашигтай болгоно.

Уян хатан байршуулалт, HA/DR

Нэг процессоос бүхэл үйлдвэр хүртэл өргөтгөх боломжтой; high-availability, disaster recovery сонголттой.

AVEVA экосистемтэй интеграц

AVEVA InTouch HMI, AVEVA Edge, AVEVA Plant SCADA, AVEVA System Platform-тэй уугуул интеграцтай.

AVEVA Historian Client — хэрэгслүүд

- **Trend (десктоп)** — бодит цагийн, түүхэн тренд; pause/play/replay; таг чирч буулгах; single/stacked, X-Y scatter, batch график; аннотаци, дохиоллын overlay; нэгж шууд солих; OMI/InTouch/Plant SCADA-д шингэнэ.
- **Query (десктоп)** — SQL мэдлэг шаардахгүй query үүсгэгч; таг чирч буулгах, баганыг checkbox-оор нэмэх/хасах, query хуулж буулгах, аннотаци татах.
- **Web (браузер)** — бүх таг, түлхүүр үгээр хайх; drilldown, stacked тэнхлэг, pan/zoom; сэтгэгдэл, дохиолол inline; хувийн контент, dashboard хадгалж хуваалцах.
- **Excel add-in** — Excel доторх самбар; live, history, aggregate, summary, event snapshot утгууд; Tag Analysis (график, статистик); дахин ашиглагдах тайлан.

Монголд — Enlight

Enlight нь AVEVA Plant SCADA төслүүдээ AVEVA Historian-тай хослуулж, процессын өгөгдлийг удирдлагын шийдвэр гаргалтын суурь болгодог — MCA усны дахин боловсруулалт (Plant SCADA + Historian), Мобиком, Тавантолгой, Эрдэнэ Монгол зэрэг.

Enlight Control Systems LLC — AVEVA-ийн Монгол дахь албан ёсны дистрибьютор. Утас: 7775-4478 · info@enlight.mn · enlight.mn

Эх сурвалж: AVEVA (aveva.com/en/products/historian). Энэ бол AVEVA-ийн материалд тулгуурлан Enlight-ийн бэлтгэсэн монгол хэл дээрх тойм юм. AVEVA болон AVEVA Historian нь AVEVA Group-ийн барааны тэмдэг. Бүтээгдэхүүний бүрэн, эх мэдээллийг AVEVA-ийн албан ёсны хуудаснаас авна уу.